

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ



**Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт
оруулах тухай хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын
зөвлөлөөс өгөх дүгнэлт**

Улаанбаатар хот

2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд “Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалтад "урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний гурван хувиар нэмэгдэх" гэж, мөн 34.1.4 дэх заалтад "төсвийн ерөнхийлөн захирагч хооронд төсвийн зохицуулалт хийх" тохиолдолд Засгийн газар тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж заасан нь Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль эрх зүйн үндэслэл болж байна” гэжээ.

Мөн “Манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ 2025 оны эхний 5 сарын дунджаар 72 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 39 хувиар, нийт экспорт 2025 оны эхний 5 сард 5.4 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 15 хувь буюу 931 сая ам.доллараар, төсвийн нийт орлого 11.4 их наяд төгрөг болж, 11 хувь буюу 1.3 их наяд төгрөгөөр тус тус буурсан. Мөн эдийн засгийн өсөлт 2023 онд 7.4 хувь, 2024 онд 4.9 хувь байсан бол 2025 оны эхний улиралд 2.4 хувь болж буураад байна. Экспорт, төсвийн орлого буурч, эдийн засгийн өсөлт саарсны улмаас 2025 онд нэгдсэн төсвийн орлого тасрахаар байгаа нь Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах шаардлагыг бий болгож байна” гэж дурдсан байна.

Гэвч төсөвт тодотгол хийх практик шаардлага хэмээн дурдаж байгаа “Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурч зарлага нэмэгдсэн” гэдэг нь хандлага нь нэгэнт тодорхой байсан, өмнөх онуудад төсөв батлахдаа тооцож болох зүйл байсан бөгөөд төсвийн орлогыг хэт өөдрөгөөр төсөөлж, дагуулаад зарлагыг нэмэгдүүлэх боломж хомс гэдгийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дүгнэлт, зөвлөмждөө байнга сануулсаар ирсэн билээ. Бид хэдийгээр улс орны эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг сайтар ойлгож байгаа боловч болзошгүй эрсдэлийг тооцох, хүндрэл бэрхшээл тулгарахад бэлтгэлтэй байх боломжийг ашиглаж чадсангүй гэдгийг дахин сануулж байна.

1. Нэгдсэн төсвийн нийт орлого ба буцалтгүй тусламж

- 1.1. Нэгдсэн төсвийн нийт орлого 2025 оны батлагдсан төсвөөр 36,435.6 тэрбум төгрөг байсныг 3,895.4 тэрбум төгрөгөөр бууруулж, 32,540.2 тэрбум төгрөгөөр, үүнээс Тогтворжуулалтын санд төвлөрөх орлогыг 179.8 тэрбум төгрөгөөр бууруулж 429.1 тэрбум төгрөг, Үндэсний баялгийн санд төвлөрөх орлогыг 455.6 төгрөгөөр бууруулж, 1,901.2 тэрбум төгрөг болгож тодотгохоор тусгажээ.

Тодотголоор Нэгдсэн төсвийн орлогыг 2025 оны батлагдсан төсөвтэй харьцуулахад 10.6 хувиар бууруулахаар оруулж байгаа нь Засгийн газар тухайн жилийн төсвийн орлогыг анх төсөвлөхдөө макро эдийн засгийн болон гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл байдал, гол нэрийн түүхий эдийн үнэ ханины төсөөллийг хэт өөдрөгөөр төсөөлж байсныг залруулах нэг оролдлого юм. Энэ нь Засгийн газар, Сангийн яам цаашидаа төсвийн төлөвлөлтийг сайжруулах, мэргэжлийн байгууллагууд болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын шинжилгээ, таамаглалыг анхаарч хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

- 1.2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11.1.3. а-д¹ заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцож, 2025 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 7,491.7 ам. доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 129 ам.доллараар тооцсон нь УИХ-аар баталсан 2025 оны төсвийн төсөл дэх үнэ өөрчлөгдөөгүй байгааг харуулж байна².

ОУВС-аас түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнийн мэдээллийг голлох түүхий эдийн үнийн системээр дамжуулан мэдээлдэг өгөгдлийн сангаас Австрали, Өмнөд Африкийн нүүрсний үнийг хамруулсан Нүүрсний үнийн индексийн дунджийг авч ашигладаг энэхүү аргачлалыг өөрчлөх хэрэгтэй болжээ. Эс бөгөөс дээрх аргачлалаас тооцсон түүхий эдийн тэнцвэржүүлсэн үнэ болон бодит үнийн хооронд ихээхэн зөрүү гарч, улмаар төсвийн орлогын дүн өндрөөр тооцогдох шалтгаан болж байгааг анхаарах хэрэгтэй.

- 1.3. Улсын нэгдсэн төсвийн орлогыг 2025 оны батлагдсан төсвөөс даруй 3,895.4 тэрбум төгрөгөөр буурахаар тооцсон байгаа нь Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 1,769.7 тэрбум төгрөгөөр буюу нийт бууралтын 45.4 хувийг, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 1,349.3 тэрбум төгрөгөөр буюу нийт бууралтын 34.4 хувь, дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 557.0 тэрбум төгрөг буюу нийт бууралтын 14.2 хувийг тус тус эзэлж байна. Энэ нь төсвийн орлогын төлөвлөлтийг бодитой үндэслэлтэй тооцож чадаагүйг харуулж байна.

Улсын төсвийн орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа эрдэс түүхий эдийн орлого дэлхийн зах зээлийн ялангуяа Хятад улсын зах зээлийн чиг хандлагаас ихээхэн шалтгаалж байгаа бөгөөд 2025 оны эхний хагас жилийн байдлаар экспортын зэс, алтны үнэ харьцангуй тогтвортой байгаа нь төсвийн орлогод эергээр нөлөөлж, харин төмрийн хүдэр, нүүрсний үнийн бууралт, хэлбэлзлээс шалтгаалан экспортын орлого төлөвлөгдсөн хэмжээнд хүрэхгүй, улмаар энэ нь төсвийн орлого бүрдэхэд сөргөөр нөлөөлж байна. Иймд цаашидаа улсын салбарын төсөв, санхүүгийн дунд болон урт хугацааны стратегийг боловсруулж, дунд хугацааны ТХМ болон жилийн төсвийн төслийг батлахдаа мөрдлөг болгодог байх шаардлагатай. Ялангуяа уул уурхай, эрдэс баялгийн салбарт тулгуурласан эдийн засгийн бүтэцтэй манай улсын хувьд мөчлөг сөрсөн макро эдийн засгийн бодлого хэрэгжүүлэх, төсвийн болон мөнгөний, валютын ханины бодлогыг зөв тодорхойлох, эдийн засаг, төсөв, санхүүгийн болзошгүй хүндрэлээс урьдчилан сэргийлэх, голланд өвчин болон баялгийн хараалаас зайлсхийхэд ихээхэн тустай байх болно.

- 1.4. Засгийн газар төсвийн тодотголын төслөөр нүүрсний экспортын дундаж үнийг 70 ам. доллароор тооцож, нүүрсний экспортын биет хэмжээг бууруулахгүйгээр өмнөх оны түвшинд буюу 85 сая тоннд хүргэхээр төлөвлөжээ. Манай улсын экспорт 2025 оны эхний 5 сарын байдлаар 5,424.6 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 15

¹ 11.1.3.а.тухайн төсвийн жилийн дараах жилийн төсвийн төсөлд баримтлах, түүний дараагийн хоёр, гурав дахь жилийн төсвийн төсөөлөлд тусгах гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг Олон улсын валютын сангаас гаргасан түүхий эдийн үнийн статистикт тусгасан тухайн төсвийн жилийн өмнөх дараалсан харгалзах 20, 19, 18 жилийн дундаж үнэ, эрдэс баялгийн үнийн төсөөллийг мэдээлдэг олон улсад нэр хүнд бүхий, Засгийн газраас тодорхойлсон санхүүгийн мэдээллийн байгууллагаас тухайн жилийн гуравдугаар сард анх зарласан өдрийн тухайн төсвийн жилийн болон түүний дараахь гурван жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тус тус тооцох;

² Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн товч танилцуулгын 38-р хуудас.

хувиар буюу 932.9 сая ам.доллароор буурч байна. Гадаад худалдааны экспортын орлого жилийн эцэст төлөвлөснөөс 3,060.0 сая ам.доллароор буурч, 15,820.0 сая ам.доллароор хүрэхээр тооцжээ.

Тус зөвлөлөөс 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдөр Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн “Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв таамаглал”-ын тайланд нүүрсний үнийг 2025 онд дунджаар 85.0 ам.доллар байхаар тооцож байсан нь төсвийн тодотголоор оруулж ирсэн үнээс 18 хувиар өндөр, харин Засгийн газар нүүрсний үнийг 2025 онд 105 ам.доллароор тооцсон нь 34 хувиар өндөр байв.

- 1.5. Манай улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн болох нүүрсний үнийг Засгийн газраас 2025 оны төсөвт 105.0 ам доллароор тусгасан боловч 2025 оны эхний 5 сарын байдлаар нүүрсний экспортын дундаж үнэ 71.9 ам доллар болж төсөөлсөн үнээс даруй 32.0 хувиар унаж төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ 3.3 их наяд төгрөгөөр тасрах үндсэн шалтгааны нэг боллоо.

Иймд голлох эрдэс баялгийн түүхий эдийн үнийн төсөөллийг хийх арга аргачлалаа маш тодорхой болгож, төсөөллийн нарийвчлалыг сайжруулах шаардлагатай.

2. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл

- 2.1. Засгийн газар 2025 оны төсвийн тодотголоор нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг батлагдсан төсвөөс 1,856.4 тэрбум төгрөгөөр бууруулж 31,575.1 тэрбум төгрөг байхаар, үүнээс урсгал зардлын дүнг 1,299.1 тэрбум төгрөгөөр бууруулж 24,005.5 тэрбум төгрөг байхаар, хөрөнгийн зардлыг 499 тэрбум төгрөгөөр бууруулж, 7,841.1 төгрөг байхаар, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүнг 58.4 тэрбум төгрөгөөр бууруулж, -271.8 байхаар тус тус тооцжээ.

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 2025 оны батлагдсан төсвөөс 5.4 хувиар бууруулж батлахаар орж ирсэн нь төсвийн орлогын бууралт болох 10.6 хувьтай харьцуулахад бага байгаа бөгөөд цаашид төсвийн нийт орлогын бууралтын хэмжээгээр зарлагын дүнг бууруулах зарчмыг баримталж орлогын тасалдлаас аль болох зайлсхийх бодлогыг тууштай баримтлах шаардлагатай байна.

- 2.2. Улсын нэгдсэн төсвийн 2025 оны тодотголоор төсвийн урсгал зарлагыг Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлттэй холбоотойгоор 261 тэрбум төгрөг, төсвийн захирагч хооронд чиг үүрэг, бүтэц шилжүүлэхтэй холбоотой 8.4 тэрбум төгрөг, төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны зардлын хэмнэлт хэлбэрээр 104.4 тэрбум төгрөг, хэрэгжиж эхлээгүй төсөл, арга хэмжээний зардлаас 617.3 тэрбум төгрөг, нийт 991.1 тэрбум төгрөгөөр бууруулж тооцсон байна. Нэгдсэн төсвийн нийт зарлага, цэвэр зээлийн дүнг 2025 оны батлагдсан төсвөөс 1,856.4 тэрбум төгрөгөөр бууруулж, 31,575.1 тэрбум төгрөг, ДНБ-д эзлэх дүнгээр 0.1 хувиар бууруулж, 35.1 хувь хүргэхээр тооцжээ.

Төсвийн тодотголоор нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг батлагдсан төсвөөс 1.8 их наяд төгрөгөөр бууруулж байгаа нь өнөөгийн дэлхийн геополитик, эдийн засгийн нөхцөл байдал, хөрш орнуудын эдийн засгийн идэвхжилтэй харьцуулахад хангалтгүй байгаа бөгөөд ядаж ДНБ-ий 33 хувьтай тэнцэх хэмжээний буюу 29,703 тэрбум төгрөг байхаар тооцож, 1,872.1 тэрбум төгрөгийн зардлыг дахин бууруулах боломжийг эрэлхийлэх

шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 1,856.4 төгрөгөөр бус 3,728.5 тэрбум төгрөгөөр бууруулж тодотгох шаардлагатай гэсэн үг. Энэ зардлыг татаас ба урсгал шилжүүлгээс тооцон гаргах нь зөв болов уу. Учир нь урсгал шилжүүлгийн зардлын дүн 11,987.4 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд тодотголоор 95.4 тэрбум төгрөгөөр л бууруулсан байна.

- 2.3. Улсын нэгдсэн төсвийн урсгал зардлыг 1.3 их наяд төгрөгөөр бууруулж 24.0 их наяд төгрөг, нийт зардлыг 1.9 их наяд төгрөгөөр бууруулж 31.6 их наяд төгрөгт тус тус хүргэж байгаа бөгөөд төсвийн урсгал зардал ДНБ-ий 26.7 хувь, төсвийн нийт зардал ДНБ-ий 35.1 хувийг эзэлж байна.

Хөгжиж байгаа орнуудын хувьд төсвийн нийт зардлын ДНБ-д эзлэх хувь 20-25 хувь байдаг бөгөөд манай улсын хувьд энэ харьцаа үзүүлэлт хөгжиж байгаа орнуудын дундаж жишигтэй харьцуулахад даруй 10.0 хувиар илүү байна. Иймд төсвийн нийт зардлыг цаашид дахин бууруулах шаардлагатай.

- 2.4. Төсвийн тодотголоор эмч, багш нараас бусад төрийн албан хаагчдын тоог 14,400 буюу 9 хувиар бууруулж байгаа бөгөөд энэ нь нийт ажиллах хүчний 16.7 хувийг эзэлж байна. Гэтэл Япон улсад төрийн албан хаагчдын тоо нийт ажиллах хүчний 5.9 хувь, БНСУ-д энэ үзүүлэлт 7.6 хувь байдаг.

Үүнээс харахад манай улсын хувьд төрийн албан хаагчдын тоо өндөр хэвээр байгаа бөгөөд цаашид төрийн зарим үйлчилгээг хувийн хэвшил болон төрийн бус байгууллагад шилжүүлэх, төрийн үйлчилгээг цахимжуулах ажлыг эрчимжүүлэх замаар төрийн албан хаагчдын тоог бууруулах бололцоотой гэж үзэж байна. Төрөөс иргэддээ хувийн хэвшилд ажиллах боломжийг дээд зэргээр хангах, бизнесийн үйл ажиллагааг боомилж буй төрөл бүрийн дүрэм журам, зөвшөөрлүүдийг боломжит хамгийн бага түвшинд хүргэх арга хэмжээг хэрэгжүүлбэл зохино.

- 2.5. Төсвийн нийт зардал ДНБ-д эзлэх хувь 35.1 хувь, төрийн болон орон нутгийн өмчит компаниудад эргэлдэж буй хөрөнгийг энэхүү төсвийн зардал дээр нэмбэл энэ хувь хэмжээ даруй 70.0 гаруй хувь болно. Энэ нь эдийн засаг дахь төрийн нийт оролцоо асар өндөр байгааг харуулж байна.

Иймд зөвхөн төрийн албан хаагчдын тоог цөөлөх, үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах чиглэлээр ажиллахаас гадна төрийн болон орон нутгийн өмчит компаниудад хийх хууль, эрх зүйн болон үйл ажиллагааны реформыг нэн даруй эхлэх шаардлагатай.

3. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж

- 3.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8,994.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 612 төсөл, арга хэмжээнд 2,982.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор 2025 төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр оруулж иржээ. Мөн түүнчлэн Төсвийн ерөнхийлөн захирагчдын багцад төсөвлөгдөж батлагдсан хөрөнгө оруулалтын дүнгээс нийт 535.9 тэрбум төгрөгийг хэмнэлтэд тооцохоор, олон улсын хурлын бэлтгэл ажил болон эрчим хүчний гэнэтийн аваар осол зэрэгтэй холбогдуулан 77.3 тэрбум төгрөгийг нэмж тусгасан байна.

Энэ оны төсвийн жилийн нөхцөл, онцлог байдлаас шалтгаалан төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гэрээ байгуулсан эсэхээс үл

шалтгаалан дахин 500 гаруй тэрбум төгрөгөөр хойшлуулах арга хэмжээ авах нь зүйтэй байна. Тухайлбал, Ерөнхийлөгчийн Тамгын газрын тоног төхөөрөмж 358.9 сая төгрөг, УИХ-ын Тамгын газрын тоног төхөөрөмж 8,560 сая төгрөг, Ерөнхий сайдын төсвийн багц дахь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын тоног төхөөрөмж 1,433.5 сая төгрөг, Эдийн засаг, хөгжлийн яамны их засвар 2,335.3 сая төгрөг, Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгийн Хэрэглээний биотехнологийн лабораторийн тоног төхөөрөмж 4,951.0 сая төгрөг, Стандарт, хэмжил зүйн газрын 4,354.4 сая төгрөг, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын харьяа байгууллагуудын их засвар 1,705.2 сая төгрөг, тоног төхөөрөмж 1,631.2 сая төгрөг, Гадаад харилцааны салбарын их засварын зардал 8,378.7 сая төгрөг, Гаалийн мэдээлэл технологи, цахимжуулалтын тоног төхөөрөмж 2,499.1 сая төгрөг, Гаалийн хяналтын тоног төхөөрөмж 7,498.2 сая төгрөг, Буйр нуурын усан замын боомт байгуулах ТЭЗҮ 899 сая төгрөг, Хууль зүй, дотоод хэргийн салбарын тоног төхөөрөмж 13,278.4 сая төгрөг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын тоног төхөөрөмж 13,936.9 сая төгрөг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын төсвийн багц дахь шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжуудын зардал 54,468.6 сая төгрөг, их засварын зардал 2,957.8 сая төгрөг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөл, цахим шилжилт, тоног төхөөрөмжийн зардал 9,477.2 сая төгрөг, Зам тээврийн сайдын төсвийн багц дахь шинээр барим замын зардал 217,314.5 сая төгрөг, Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдын шинээр хэрэгжүүлэх 54,495.1 сая төгрөг, ТЭЗҮ-ийн зардал 12,160.0 сая төгрөг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын шинээр хэрэгжүүлэх Бэлчээрийн усан хангамжийн зардал 1,476.9 сая төгрөг, Авлигатай тэмцэх газрын их засвар 960.7 сая төгрөг, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийн төсвийн багц дахь цахим систем 561.8 сая төгрөг, шинэ төсөл тоног төхөөрөмж 3,527.9 сая төгрөг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн барилга байгууламжийн шинэ төсөл 50,361.4 сая төгрөг, Санхүүгийн зохицуулах хорооны мэдээллийн нэгдсэн систем 243.4 сая төгрөг, Шүүхийн сахилгын хорооны тоног төхөөрөмж 300 сая төгрөг, Үндэсний статистикийн хорооны тоног төхөөрөмж 1,804.2 сая зэрэг шинээр барих барилга байгууламж, их засвар, авто зам, тоног төхөөрөмжүүд зэрэг байна.

- 3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл санхүүжилтийн дүнгээр тооцвол 6 дугаар сарын 24-ны байдлаар 12 хувьтай байгаа нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 2025 оны 5 дугаар сарын 31-ний дотор худалдан авах ажиллагааг бүрэн дуусгах, гэрээ байгуулаагүй төслүүдийн санхүүжилтийг хэмнэлтэд тооцох, зарцуулахгүй байх зохицуулалтын хүрээнд 535.9 тэрбум төгрөгөөр улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг бууруулж байна. Засгийн газрын 14 мега төслийн 4 төслийг үргэлжлүүлж, 5 төслийг түр хойшлуулж, бусад 5 төслийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр тооцож байна.

Гэвч улсын төсвийн хөрөнгө оруулалтын бусад төслүүдийн хувьд ач холбогдлын эрэмбэлэлтийг дахин хийх, төсөвт өртгийн тооцооллыг эргэж хянах, онцын шаардлагагүй төслүүдийг жагсаалтаас хасах талаар тодорхой ажлууд хийгдсэн эсэх нь төсвийн тодотголын тайлан материалд тодорхойгүй байна.

Дүгнэлт

1. Сүүлийн жилүүдэд нүүрсний экспортын үнэ, биет хэмжээ, бусад эрдсийн түүхий эдийн зах зээлийн үнэ, уул уурхайн салбар, түүнийг дагасан тээвэр, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт нь төсвийн орлого нэмэгдэх шалтгаан болж, түүнд дулдуйдсан төсвийн хэт тэлэлт огцом явагдсан. Зөвхөн УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагуудын хувьд 2025 оны нийт зардлын хэмжээ 2020 онтой харьцуулахад 2.3-10.7 дахин өссөн нь үүнийг нотлох баримт юм.
2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 10.1.3-т “Төсвийн төсөл болон батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх” гэж заасан. Гэсэн ч төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн жилийн төсвийн болон тодотголын төсөлд нийцүүлэн өөрчилдөг байдал давтагдсаар байна. Тухайлбал, тус хууль анх батлагдсанаас хойш 19 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.
3. 2024 оны 8 дугаар сарын 13-ний өдөр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн дүгнэлтдээ “Монгол Улсын 2024 оны батлагдсан төсөвт тодотгол хийхээс илүүтэй ирэх 2025 оны төсөвт хөрөнгө оруулалтын төслүүдийг шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусгах нь зохистой гэж үзэж байна” гэж дурдсан. Тухайн үед төсвийн тодотгол өргөн барих хуулийн үндэслэл нь Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөн тухай асуудал байсан боловч үүнд хамааралгүй зардлуудыг тусгаж төсвийн зарлагын 3 их наяд төгрөгөөр нэмэгдүүлсэн. Жишээлбэл, эхлэх дуусах хугацаа, нийт төсөвт өртөг нь тодорхойгүй, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2021-2025 оны Хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол Улсын 2024 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй төслүүдийг санхүүжүүлэхэд 342.6 тэрбум төгрөг төсөвлөж, он дуусахаас гурваас дөрөвхөн сарын хугацаанд урьдчилсан ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах, зөвлөх үйлчилгээ авах, бэлтгэл ажлыг хангах болон хөгжлийн төслүүдийн нэгдсэн менежментийн зөвлөх үйлчилгээ зэрэгт 173.8 тэрбум төгрөгийг зарлагадсан. Үүний бодит үр дүнг татвар төлөгчид, иргэд нэхэх, мэдэх эрхтэй.
4. Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээг өсгөж, төрийн эдийн засаг дахь оролцоог байнга нэмэгдүүлсээр ирсэн нь хувийн хэвшлийг дэмжих, эдийн засгийн суурийг тэлэх боломжийг хязгаарлах нөхцөл болж байгаа учраас хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд цалингаа тавих, татвараа төлөх, өр зээлээ барагдуулах байнгын дарамтад ажиллаж байна. Хэрвээ бид нөхцөл байдлаа зөв үнэлж мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж ирсэн бол төр, хувийн хэвшил харилцан бие биеэ дэмжиж “хэт өлсөхгүй, хэтэрхий цадахгүй” хэвийн амьдрах боломж байсан гэдгийг тэмдэглэе.
5. Тухай байгууллагын бүтэц орон тоо, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний хэмжээ хоорондоо урвуу хамааралтай боловч аль аль нь зэрэг нэмэгдэх хандлага хэвээр үргэлжилж байна. Үүнийг төрийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлээс тодорхой харж болно. Ийм учраас төрийн албаны цалин хөлс нь ажлын үр дүн, бүтээмжтэй хэр нийцэж байгааг үнэлж, ялгаатай тогтоосон хэд хэдэн итгэлцүүрийг эргэж харах шаардлагатай гэж үзнэ.
6. Макро бодлогын түвшинд харвал бид өнөөг хүртэл төсвийн хүндрэлийг бодлого, төлөвлөлтөөр бус, тодотголоор даван туулж ирлээ. Монгол хэлний товч тайлбар тольд төсвийг “албан байгууллага, улсаас ямар нэгэн тодорхой хугацаанд зарцуулах

зарлага, оруулах орлогыг таацуулан бодсон бүдүүвч төлөвлөгөө” гэсэн бол эртний Энэтхэгийн улс төр, эдийн засгийн ухааны Артхашастра зохиолд “Захирагч юун түрүүнд тухайн жилийн орлогыг таамаглах хэрэгтэй. Ингэхдээ газар бүрээс болон үйл ажиллагааны төрөл бүрээс ирэх боломжит орлогыг таамаглан, тус бүрийг салган бүртгээд үйл ажиллагааны төрлөөр нь нэгтгэн нийлбэр дүнг гаргаж авах хэрэгтэй” гэжээ. Харин энэ цаг үед ОУВС-ийн төсвийн зарлагыг удирдах зарчмууд, ЭЗХХАБ-ын төсвийг удирдах зарчмууд зэрэгт олон улсын хэм хэмжээг тодорхойлсон байдаг. Гэвч бид 2008 оны эдийн засгийн хямрал, 2018 оны АНУ-ын худалдааны татварын бодлого, Ковид-19 цар тахал зэрэг олон улсын эдийн засгийн хямрал, хүндрэлийг тухайн үед нь төсвөө тодотгох замаар зохицуулж ирсэн нь нөхцөл байдал нэгэнт хүндэрсэн үед зайлшгүй гарц мэт боловч төсвийн төлөвлөлтийн гол онцлог нь хүндрэлийг урдаас таацуулан бодоход оршиж буйг эргэн санах шаардлагатайг харуулж байна.

7. Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавх нь эрсдэл, өртөнгө, эмзэг байдлыг бууруулах чадварыг нэмэгдүүлэх замаар сайжирдаг. Манай улс дунд хугацааны төсөвлөлтийн эхний үе шат болох дунд хугацааны макро эдийн засгийн хүрээг нэвтрүүлсэн хэдий ч хүрээ нь төсвөө, төсөв нь тодотголоо даган өөрчлөгддөг байдал үргэлжилсээр байгаа нь эрсдэлийг мэдрэх гол арга хэрэгслийг үр дүнгүй болгож эмзэг байдлыг нэмэгдүүлэн үндэсний сөрөн тэсвэрлэх чадварт сөргөөр нөлөөлж байна.